



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/172

Эрдэнэт

### Устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3./а/, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.8, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.4 дэх заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны сэг зэмээр байгаль орчин бохирлогдож хүн, малын халдварт өвчин гарч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн малчдын байршиж байгаа нутаг дэвсгэрт хорогдсон малын сэг зэмийг устгах, хашаа хороо, өтөг бууц, бэлчээр, худаг ус, булаг шандыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах шатахууны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн нийт малчдын байршиж байгаа нутаг дэвсгэр дэх хорогдсон малын сэг зэмийг устгах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг 2018 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 01-ний хооронд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохих журмын дагуу зохион байгуулж дуусган, цаашид хорогдсон малын сэг зэмийг малчид, иргэдийн хүчээр цаг тухай бүрт нь устгал хийж, халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт, мал, амьтны сэг зэм устгах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хийх заавар, зөвлөмж гарган, үйл ажиллагааны явцад үзлэг, тандалт хийж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган үр дүнг танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Онцгой байдлын газар /н.Ганбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

3. Мал амьтны сэг зэм устгах, өвөлжөө хаваржааны ариутгал халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах 12132000 /арван хоёр сая нэг зуун гучин хоёр мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилагдсан зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Малын сэг зэмийг устгах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /н.Жигдэнгомбо/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны  
3... дугаар сарын 29...-ны өдрийн  
А/172... дугаар захирамжийн хавсралт

МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМ УСТГАХ, АРИУТГАЛ  
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Төрөл	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо хэмжээ /ш/	Бүгд үнэ /төг/	Тайлбар
1	Шатахуун зардал	A/80	литр	1620	1685	2730000	Тээвэр
2	Ковш	ДТ түлш	литр	2050	900	1845000	Нүх ухах, өргөх, булах
3	Ариутгалын бодис хүргэх, ажлын зураглал гаргах, хяналт тавих	A/80	литр	1620	350	567000	ХХААГ МХГ ОБГ
4	Хөдөлмөр хамгаалалын зардал	Урт резин бээлий	ш	50	1800	90000	Мэргэжлийн багт олгох
5	Ажиллах хүмүүсийн хоол, хүнсний зардал	Жолооч малын эмч туслах ажилтан	Хүн өдөр	10000	20x10	2000000	Туслах ажилтан-10 Малын эмч -5 Жолооч -5
6	Шар усны үертэй холбоотой гудамж талбайн ариутгал хийх	Хлорын шохой	кг	7000	700	4900000	Баян-Өндөр, Жаргалант, сумын нийтийн эзэмшлийн талбай, гудамж, түүхий эдийн цэг, худалдааны төв
	<b>Дүн</b>					<b>12132000</b>	